



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар Н/02

Цагаан-Уул сум

Г
Ахмадын гэрийг хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын ахмадын хороонд ашиглагдаж байгаа Ахмад настнуудын гэрийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ш.Эрдэнэцэцэг (Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Ж.Пүрэвжав (Өндөр настан)

Д.Бадамноров (Ахмадын хорооны менежер)


Н.Алтангэрэл (Засаг даргын Тамгын газрын нярав)

Нарийн бичгийн дарга: А.Энхбаатар (Газрын даамал)

2. Ахмадын гэрийг хүлээн авахдаа гэрийн мод, дээвэр туурга, бүрээс бусад эд зүйлийн бүрэн бүтэн байдлыг сайтар хянаж тэмдэглэн хөтлөн хүлээн авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Алтанбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ